| **“МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС” ХХК** | | |
|---|---|---|
| Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/ | | |
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | | |
| | | |
| *Тайлагнах хугацаа* | | 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | | Нэр: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК<br>УБГД: 9011826709<br>РД: 6702988<br>Үнэт цаасны код: MFG, MN00MFG40026/ISIN/<br>Хаяг: Монгол Улс, Улаанбаатар, СБД 1-Р хороо, Жамьян Гүний Гудамж, Меру Тауэр, 602 тоот<br>Утас: 75750 9911<br>И-мэйл хаяг: finance@mandalasset.mn<br>Вэбсайт: www.mandalasset.mn |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | | “Монголын Хөрөнгийн Бирж” ХК |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | | Санхүү |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | | “Нексиа Аудит Монголиа” ХХК |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | | 50,000,000 ширхэг |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, Санхүүгийн тайланг хянасан албан тушаалтны нэр* | | Бэлтгэсэн: “Мандал Ассет менежмент ҮЦК” ХХК-ийн хөрөнгө оруулалтын мэргэжилтэн<br>Г.Ундармаа............Ундармаа..........2025.03.31<br>Хянасан: “Мандал Ассет менежмент ҮЦК” ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч<br>О.Мандухай……………………………2025.03.31 |
| | | |
| 1. | *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | |
| | ***Санхүүгийн байдлын үзүүлэлт*** | |

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| *(Мянган төгрөгөөр)* | Тодруулга | 2024-12-31 | 2023-12-31 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | |
| Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө | 17 | 208,021 | 726,477 |
| Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө | 17 | 8,166,763 | - |
| **Нийт эргэлтийн бус хөрөнгө** | | **8,374,784** | **726,477** |
| **Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө | 17 | 27,709,577 | 22,084,097 |
| Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө | 17 | 31,688,554 | 36,101,052 |
| Бусад авлага | 19 | 1,083,513 | 1,324,995 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 18 | 2,070,041 | 121,584 |
| **Нийт эргэлтийн хөрөнгө** | | **62,551,685** | **59,631,728** |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **70,926,469** | **60,358,205** |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ** | | | |
| Нэгж эрх | 20 | 50,000,000 | 50,000,000 |
| Бусад нөөц | 21 | (276,448) | 409,365 |
| Хуримтлагдсан ашиг | | 18,066,719 | 9,669,518 |
| **НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ** | | **67,790,271** | **60,078,883** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | |
| Бусад өглөг | 22 | 3,136,198 | 189,946 |
| **Нийт богино хугацаат өр төлбөр** | | **3,136,198** | **189,946** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | | |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 16 | - | 89,376 |
| **Нийт хугацаат өр төлбөр** | | **-** | **89,376** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **3,136,198** | **279,322** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ** | | **70,926,469** | **60,358,205** |

***Орлогын тайлан***

## ОРЛОГО ҮР ДҮНГИЙН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

| *(Мянган төгрөгөөр)* | Тод | 2024 | 2023 |
|---|---|---|---|
| Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого | 9 | 3,843,793 | 1,873,289 |
| Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого | 9 | 3,962,322 | 2,287,045 |
| Ногдол ашгийн орлого | 10 | 1,509,205 | 718,452 |
| Бусад орлого | 11 | 86,777 | 213,238 |
| Хорогдуулсан өртгөөр хэмжсэн өрийн хэрэглүүрийн арилжааны олз/ гарз | 12 | 1,104,430 | 489,430 |
| Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн ашиг, алдагдалд шилжүүлсэн бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт | 12 | 51,058 | 477,953 |
| **Нийт орлого** | | **10,557,585** | **6,059,407** |

| | | | |
|---|---|---|---|
| ХОМК-ийн үйлчилгээний зардал | 14 | (1,502,480) | (566,497) |
| Кастодианы үйлчилгээний зардал | 14 | (62,494) | (83,219) |
| Бусад зардал | 15 | (272,111) | (74,872) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз/(гарз) | 13 | (200,400) | 596,343 |
| **Нийт үйл ажиллагааны зардал** | | **(2,037,485)** | **(128,245)** |
| **Татварын өмнөх ашиг** | | **8,520,100** | **5,931,162** |
| Орлогын албан татварын зардал | 16 | (129,256) | (226,761) |
| **ТАЙЛАНТ ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ** | | **8,390,844** | **5,704,401** |
| Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт | 21 | (685,813) | (562,091) |
| **НИЙТ БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО** | | **7,705,031** | **5,142,310** |
| Нэгж эрхийн тоо | 20 | 50,000,000 | 50,000,000 |
| Нэгж эрхэд ногдох суурь ашиг (төгрөгөөр) | | 168 | 114 |

***Өмчийн өөрчлөлтийн тайлан***

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН

ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| *(Мянган төгрөгөөр)* | Нэгж эрх | Хуримтлагдсан ашиг | Бусад нөөц | Нийт цэвэр хөрөнгө |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **50,000,000** | **(157,351)** | **-** | **49,842,649** |
| Тайлант жилийн ашиг | - | 4,122,468 | - | 4,122,468 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | 971,456 | 971,456 |
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **50,000,000** | **3,965,117** | **971,456** | **54,936,573** |
| Тайлант жилийн ашиг | - | 5,704,401 | - | 5,704,401 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | (562,091) | (562,091) |
| **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **50,000,000** | **9,669,518** | **409,365** | **60,078,883** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | (49,486) | - | (49,486) |
| **2024 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл** | **50,000,000** | **9,620,032** | **409,365** | **60,029,397** |
| Тайлант жилийн ашиг | - | 8,390,844 | (685,813) | 7,705,031 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | 55,843 | - | 55,843 |
| **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **50,000,000** | **18,066,719** | **(276,448)** | **67,790,271** |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

***Мөнгөн гүйлгээний тайлан***

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| *(Мянган төгрөгөөр)* | Тод | 2024-12-31 | 2023-12-31 |
|---|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| **Татварын өмнөх ашиг** | | 8,520,100 | 5,931,162 |
| Татварын өмнөх ашгийг цэвэр мөнгөн гүйлгээтэй тохируулах мөнгөн бус тохируулга: | | | |
| Хүүгийн орлого | 9 | (7,806,115) | (4,160,334) |
| Ногдол ашгийн орлого | 10 | (1,509,205) | (718,452) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз/гарз | 13 | (308,176) | 66,395 |
| Хорогдуулсан өртгөөр хэмжсэн өрийн хэрэглүүрийн арилжааны (олз)/гарз | 12 | (1,104,430) | (489,430) |
| БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжсэн (олз)/гарз | 12 | (51,058) | (477,953) |
| | | **(2,258,884)** | **151,388** |

| | | | |
|---|---|---|---|
| Ажлын капиталын өөрчлөлт: | | | |
| Хорогдуулсан өртгөөрх бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө оруулалтын цэвэр бууралт/(өсөлт) | 17 | (5,107,025) | 5,855,074 |
| БДОБҮЦ-ээрх бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө оруулалтын цэвэр бууралт/(өсөлт) | 17 | (3,754,264) | (12,424,484) |
| Санхүүгийн хөрөнгийн бодит бус олз/гарз | | 690,351 | - |
| Бусад авлагын (өсөлт)/бууралт | 19 | 241,482 | - |
| Урьдчилж төлсөн төлбөрийн (өсөлт)/бууралт | | - | 64,216 |
| Хойшлогдсон татварын хөрөнгийн (өсөлт)/бууралт | | 89,376 | - |
| Бусад өглөгийн (бууралт)/өсөлт | 22 | 2,946,252 | (367,386) |
| Төлсөн албан татвар | 16 | (129,256) | (132,519) |
| Хүлээн авсан хүүгийн орлого | | 7,212,644 | 4,439,338 |
| Хүлээн авсан ногдол ашиг | 10 | 1,509,205 | 718,452 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **1,439,881** | **(1,695,921)** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө дэх гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө | 13 | 508,576 | (395) |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт** | | 1,948,457 | (1,696,316) |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 19 | **121,584** | **1,817,900** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 19 | **2,070,041** | **121,584** |

1.1. *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт*

*Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Сангийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэв. Дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Сангийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.*

1.2. *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/*

A member of Nexia International

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

*"Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан" ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдэд*

### Аудиторын дүгнэлт

Бид "Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан" ХХК (цаашид "Сан" гэх)–ийн 2024 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Сангийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Сангийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Сангийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Сангийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Сангийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Сангийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.
- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Сангийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Сангийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Сангийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангуудын (үүнд тодруулгууд багтана) ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Сангийн удирдлагад мэдэгддэг.

### Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Мандал Ирээдүйн Өсөлт Хөрөнгө Оруулалтын сан ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн сангийн нэгж эрх эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид

| Гарын үсэг | Баталсан |
|---|---|
| **У. Нарандэлгэр** | **Э. Булган** |
| Аудитор | Партнер |

Монгол Улс, Улаанбаатар хот
2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

**Нексиа Глобал Монголиа Аудит ХХК**
*Нексиа Интернэйшнл-ийн албан ёсны гишүүн*
Веб: www.nexia.com

| | | |
|---|---|---|
| 2. | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | |
| 2.1. | *Үйл ажиллагааны үр дүн /Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд/* | Сангийн нийт хөрөнгө ₮69.08 тэрбум хүрсэн ба нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэ цэн 1,381.76 төгрөг байна. Энэ нь өмнөх оноос 14%-иар, сан үүсгэн байгуулагдсанаас хойш 38%-иар өссөн үзүүлэлт юм. Сангийн нийт хөрөнгийн 41%-ийг мөнгөний захын хэрэгсэл, 22%-ийг хувьцаа, 37%-ийг тогтмол орлоготой үнэт цаасанд байршуулсан байна. Сан нь "Биржийн бус зах зээл"-ийн арилжаанд оролцож болох хууль эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд бондын нийт багцын 48%-г хаалттай, 52%-ийг нээлттэй өрийн хэрэгсэлд байршуулаад байна. |
| 2.2. | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | |
| 2.3. | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл* | |
| 2.4. | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | Нягтлан бодох бүртгэлийн хувьд 2025 оны 12-р сарын 09-ний өдөр Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 328/336 тоот тушаал бүхий "Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нятлан бодох бүргэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар болон" 2016 оны 06 сарын 10-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны 198 тоот тушаал бүхий "Хөрөнгө оруулатын сангийн нятлан бодох бүртгэл хөтлөх, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогчийн бүртгэх тухай журам"-уудын дагуу МНБ бүртгэлийг хөтлөн үйл ажиллагаа явуулж байна. |
| 2.5. | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл* | Байхгүй |
| 3. | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |
| | Байхгүй | |
| 4. | *Цалин урамшууллын мэдээлэл* | |
| | Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 21.2.5-д "хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулалтын санд ажилтан авч ажиллуулах"-ыг хориглодог.<br>Сан нь " Мандал Ассет Менежмент ҮЦК" ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу үйлчилгээний төлбөр төлдөг. | |
| 5. | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* | |
| | **Сангийн эрх барих дээд байгууллага нь Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал байна.**<br><br>"Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС" ХХК-ийн 2024 оны 04 сарын 22-ны өдрийн 10 цагт | |

| | |
|---|---|
| | Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд 25,608,717 ширхэг нэгж эрх эзэмшдэг 334 нэгж эрх эзэмшигч оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 50,000,000 ширхэг нэгж эрхийн 51.22% ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдаж, хурал хүчин төгөлдөр болов.<br>Хөрөнгө оруулагчдын оролцооны тэгш байдлыг хангахын тулд хурлын материалыг цахим орчинд байршуулж, цахимаар хуралдсан болно.<br>Хурлаар доорх асуудлуудыг хэлэлцэн батлав:<br><br>1. "*ХОС-ын 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах*" асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 12,928,543.00 ширхэг нэгж эрх буюу 50.10%, татгалзсан 141,041.00 ширхэг нэгж эрх буюу 0.55%, түдгэлзсэн 12,737,168.00 ширхэг нэгж эрх буюу 49.36% байна.<br>2. "*Мандал Ассет Менежмент ҮЦК" ХХК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний 2023 оны жилийн тайланг батлах*" асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,087,614.00 ширхэг нэгж эрх буюу 50.71%, татгалзсан 147,537.00 ширхэг нэгж эрх буюу 0.57%, түдгэлзсэн 12,571,601.00 ширхэг нэгж эрх буюу 48.71% байна.<br>3. "*Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний 2023 оны жилийн тайланг батлах*" асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,063,989.00 ширхэг нэгж эрх буюу 50.62%, татгалзсан 75,365.00 ширхэг нэгж эрх буюу 0.29%, түдгэлзсэн 12,667,398.00 ширхэг нэгж эрх буюу 49.09% байна.<br>4. "*ТУЗ-ийн 2024 үйл ажиллагааны зардлын төсөв батлах*" асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,140,714.00 ширхэг нэгж эрх буюу 50.92%, татгалзсан 75,265.00 ширхэг нэгж эрх буюу 0.29%, түдгэлзсэн 12,590,773.00 ширхэг нэгж эрх буюу 48.79% байна.<br>5. "*СЗХ-ны шинэчлэгдсэн "Хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу сангийн Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт (ХОБББ)-т өөрчлөлт оруулах тухай*" асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,312,845.00 ширхэг нэгж эрх буюу 51.59%, татгалзсан 60,941.00 ширхэг нэгж эрх буюу 0.24%, түдгэлзсэн 12,432,966.00 ширхэг нэгж эрх буюу 48.18% байна.<br>6. "*Сангийн дүрмийн 10.4.14-д "Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах" гэж нэмэлт өөрчлөлт оруулах тухай*" асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 13,223,966.00 ширхэг нэгж эрх буюу 51.24%, татгалзсан 82,066.00 ширхэг нэгж эрх буюу 0.32%, түдгэлзсэн 12,500,720.00 ширхэг нэгж эрх буюу 48.44% байна.<br><br>**ТУЗ нь Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Сангийн эрх барих байгууллага байна.**<br>Сангийн ТУЗ нь тогтмол хуралдаж сангийн нэгж эрх эзэмшигчдийг төлөөлөх, эрх ашгийг хамгаалах, үр ашигтай шийдвэр гаргах улмаар үйл ажиллагааг хянах, хөрөнгө оруулалтын стратегийг тодорхойлох үндсэн чиг үүрэгтэйгээр ажилладаг.<br>Сангийн ТУЗ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүйгээр, хараат бусаар Сангийн нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавин ажилладаг. Сангийн ТУЗ- ийн гишүүд нь банк, даатгал, үл хөдлөх хөрөнгө зэрэг салбарт ажиллаж байсан туршлага, чадвартай болно.<br><br>ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД<br>ТУЗ-ийн дарга Р.Амаржаргал<br>Хараат бус гишүүн Н.Монсор<br>Хараат бус гишүүн Ц.Батсүх<br>Хараат бус гишүүн Ч.Анхбаяр<br>Хараат бус гишүүн Ж.Дэлгэрсайхан |

| | |
|---|---|
| 6. | *Зах зээлийн эрсдлийн мэдээлэл* |
| | Сангийн хувьд хөрөнгө оруулалтын хороогоор баталсан бодлогоор дамжуулан эрсдэлийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлдэг. Ингэхдээ хөрвөх чадварын, хүүгийн түвшний, хөрөнгө оруулалт чанаргүйдэх зэрэг эрсдэлийг голлон авч үздэг.<br><br>**Хөрвөх чадварын эрсдэл.**<br>Тогтмол орлоготой үнэт цаасанд хөрөнгө оруулах нь хугацааны эцэст хөрөнгө оруулалтаа авдаг онцлогтой тул хөрвөх чадварын эрсдэлийг бий болгож байдаг.<br>Өнгөрсөн оны хувьд бид орох мөнгөн урсгалын давтамжийг өндөр байлгах хөрөнгө оруулалтуудыг хийж хөрвөх чадварын эрсдэлийг удирдаж ажилласан.<br><br>**Хүүгийн түвшний эрсдэл**.<br>Суурь хүү буюу бодлогын хүү буурах нь тогтмол орлоготой үнэт цаасны хүү буурах нөхцөл болж улмаар тогтмол орлоготой үнэт цаасны хөрөнгө оруулалтын үнэ цэнийг бууруулж байдаг.<br>Өнгөрсөн оны хувьд бодлогын хүү үе шаттай буурч тогтмол орлоготой үнэт цаасны хөрөнгө оруулалтын өгөөжид сөргөөр нөлөөлөх нөхцөл бий болсон.<br>Бидний зүгээс энэхүү нөхцлийг урьдаас таамаглан, хүүгийн түвшин өндөр саруудад хөрөнгө оруулалт хийх замаар хүүг түгжиж хүүгийн түвшний эрсдэлийг удирдаж ажилласан.<br><br>**Хөрөнгө оруулалт чанаргүйдэх эрсдэл**.<br>Үнэт цаас гаргагч санхүүгийн хүндрэлд орж татсан хөрөнгө оруулалтаа эргэн төлж чадахгүй нөхцөлд орох нь аливаа хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлж, үнэ цэнийг бууруулж байдаг.<br>Бидний хувьд эдийн засгийн нөхцөл байдлаас эхлэн үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа эрхэлж буй сектор, түүнд эзлэх байр суурь, санхүүгийн нөхцөл болон компанийн засаглал гэх мэт суурь үзүүлэлтүүдийг бодитоор судалж хөрөнгө оруулалтын шийдвэр гаргадаг. Улмаар фундаментал буюу санхүүгийн суурь үзүүлэлт сайтай үнэт цаас гаргагчийг олж хөрөнгө оруулах замаар хөрөнгө оруулалт чанаргүйдэх эрсдэлийг удирдаж ажилласан. |
| 7. | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* |
| | "Мандал Ассет Менежмент ҮЦК" ХХК-5.09%<br>"Тэнгэр Даатгал" ХХК-12.63% |
| 8. | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* |
| | Тайлант хугацаанд нэмж нэгж эрх гаргаагүй болно. |
| 9. | *Ногдол ашгийн мэдээлэл* |
| | Сангийн ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 01 тогтоолын дагуу 2024 оны цэвэр ашгаас нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн болно. |
| 10. | *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |
| | Мөнгөний менежер цахим сэтгүүл Харилцагчийн хөрөнгө оруулалт болон бизнесийн шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор валютын ханш, макро эдийн засгийн төлөв, зээл, хүүгийн түвшний судалгааг бэлтгэн, 40,000 хөрөнгө оруулагчдад хүргэн ажилласан.<br>Хуримтлалын анги хөтөлбөрийг хэрэгжүүлж 45,000 хүнд хүргэсэн ба хичээл нь санхүү, мөнгөний сэтгэл зүй, дадлын хичээлүүд багтсан. |

| Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: 2024.03.31 |
|---|
| *Овог, нэр: Б.Батхишиг*<br><br>*Албан тушаал: "Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС" ХХК-ийн гүйцэтгэх удирдлагын итгэмжлэгдсэн төлөөлөгч*<br><br>*Гарын үсэг: ……Б.Батхишиг……………/Б.Батхишиг/*<br><br>*(Тамга/тэмдэг)* УЛААНБААТАР ХОТ МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС ХХК 9021060636 ж 6702988 |
| Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: |
| *Овог, нэр:*<br><br>*Албан тушаал:* Хөрөнгө Оруулалтын Мэргэжилтэн.<br><br>*Гарын үсэг: ……Ундармаа……………//*<br><br>*(Тамга/тэмдэг)* |